НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 15 өдөр Дугаар А/1354 Улаанбаатар хот

Газар эзэмших эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.4 дэх заалт, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 01-05/7417 дугаар албан бичигт тусгасан саналын дагуу энэ захирамжийн хавсралтад заасан 1 (нэг) төрийн байгууллагад газар эзэмших эрх олгосугай.

2.Энэ захирамжийн хавсралтад заасан төрийн байгууллагатай холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба (Г.Мөнхбаатар)-нд даалгасугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн “Газар эзэмших, ашиглах эрх олгох тухай” А/1067 дугаар захирамжийн хавсралтын “2” дахь заалт Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газарт холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАР

1110206211

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн A/1354 дугаар захирамжийн хавсралт

## ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХ ОЛГОГДОЖ БАЙГАА ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА

| № | Газар эзэмшигч төрийн байгууллагын нэр | Регистрийн дугаар | Байршил (хороо) | Зориулалт | Хэмжээ (м.кв) | Хугацаа (жил) | Эдэлбэрийн хэлбэр | Эрх олгох үүсвэр (үндэслэл), Хурлын дугаар |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Баянгол дүүрэг** | | | | | | | | |
| 1 | Нийслэлийн Боловсролын газар | 9077065 | 30 | Боловсролын байгууллага | 3774 | 15 | Эзэмшүүлэх | НЗД-ын 2018 оны А/1067 Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, 1680110045,Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 05/2143 дугаар албан хүсэлт, ГЭАЭХШЗ-ийн 2024 оны №37 |